

Бэлтгэсэн: ШУА-ийн Газарзүй-Геологийн Хүрээлэнгийн Цөлжилтийн судалгааны салбарын ЭШДаА О. Ишцог


Орхон сумын элс бүхий талбайн хэв шинж болон түүний өөрчлөлт

Сэлэнгэ аймгийн Орхон сум нь Элсний мужлалтын ангилалаар Сэлэнгэ-Туул голын мужын Орхон-Цээл-Дүрс нарсны дэд мужид хамаарагдах ба салхи-голын гарал үүслийн хэв шинжид багтана.

Тус дэд районы нийт элс нь 91.3 км² бөгөөд Монгол орны хойт хэсгийн (Хангайн) хэмжээнд тархсан элсний 6 хувийг, улсын хэмжээнд 0.2 хувийг тус тус эзэлнэ [2].

Орхон, Сэлэнгийн ай савын голуудын хандий хотос, тэдгээрийн хажуу, голын дэнжүүдэд дарагдмал элсэн давхарга дэлгэр тархсанг өмнөх үеийн судлаачид (С.М.Дудин, Н.Т.Левин нар 1982, И.Ф.Молодых, Н.И.Толстихин нар 1920, В.А.Обручев 1945; 1947, Э.М.Мурзаев 1947; 1952, Е.И.Селиванов 1967, З.Мөнхөө 1972) тэмдэглэсэн нь бий бөгөөд Идэр голын дагуу Тосонцэнгэл хот орчимд, Сэлэнгэ мөрөн, Эгийн голын зарим хэсэгт, Орхон-Туул, Орхон-Хараа голуудын уулзвар орчимд, мөн Сүхбаатар, Алтанбулаг хотуудын ойролцоо орших хэсэг хэсэгхэн элс нь эдгээрийн жишээ болно. Сүхбаатар хотоос баруун урагш, Царам (894.0) уулын хойгуур Орхон Сэлэнгийн бэлчирийн тэгш тал болон, Алтанбулаг хотоос баруун урагш голын хөндийн хоёр талаар нэлэнхүй дарагдмал элстэй, тэдгээрийн зарим нь элэгдэл эвдрэлд орж довцог, молцог, ганц нэг манхан үүсгэсэн байх ба эдгээр элсний гарал, насны талаар Е.И. Селиванов (1967) өөрийн санаа бодлоо илэрхийлжээ. Тэрээр, дээрх хэсгийн элс газрын гүнээс бялхаж гарсан хүрмэн лав эртний голын усыг хааснаас тогтсон неоген-дөрөвдөгч галавын асар том нуурын хурдас юм гээд Орхон голын хөндийд Өгий нуурын хотгорт тунаж хуримтлагдсан давхраат элсийг дээрхийн адил гаралтай гэж үзжээ. Давхраат элс зөвхөн хагдмал нуурт төдийгүй, ер нь уулс хоорондын хотгор дахь хөндийн хэсгүүдэд бий болж байсныг З.Мөнхөө (1972) тэмдэглэжээ [2].

Бид элсний ялгаварын нормчилсон индексийг Ландсат 7 болон 8 дугаар хиймэл дагуулын мэдээг ашиглан бодуулахад дараах үр дүн гарч байна. (*1 дүгээр зураг*).




1 дүгээр зураг. Орхон сумын 2003 болон 2018 оны элс бүхий талбай

Дээрх зураглалаас харахад элс бүхий талбай 2003 онд сумын төвийн хойд хэсгээр буюу Орхон голын дагуу тархалттай байсан ба 2018 онд үгүй болсон харин Шийрийн голын хөндий дагуу бага зэрэг элсний талбай нэмэгдсэн бол элсэрхэг газрын талбай тариалан бүхий талбайд илэрч байгаа өссөн байгаа нь харагдаж байна (1 дүгээр хүснэгт).

1 дүгээр хүснэгт. Орхон сумын элс болон элсэрхэг газрын талбайн өөрчлөлт

Он	2003	2018	Өөрчлөлт
	Талбайн хэмжээ (км ²)		
Элс	13	13.6	+ 0.6
Элсэрхэг газар	25.7	49.3	+ 23.6



2003 болон 2018 оны хооронд нийт 15 жилийн хугацаанд элсний талбай 0.6 км² –аар нэмэгдсэн, харин элсэрхэг газрын талбай 23.6 км² буюу 50 орчим хувиар нэмэгдсэн байна (1 дүгээр тахирмаг). Энэ нь байгаль цаг уурын болон нийгмийн хүчин зүйлийн нөлөөн дор үйлчлэл явагдсантай холбоотой хэмээн таамаглаж байна. Тухайлбал, малын тоо толгой болон газар тариалангийн талбай хэт өссөн, агаарын температур олон жилийн дундажаас нэмэгдэн

1 дүгээр тахирмаг. Орхон сумын элс бүхий талбайн өөрчлөлт


хур тунадас багассан зэрэг болно. Тус суманд тариалан бүхий талбайд элсэрхэг газар нэмэгдсэн нь илт харагдаж байна.

Сумын нутаг дэвсгэрийн өмнөд хэсгээр Тавангийн нурууны нам уулс, цав толгод зонхилох бол хойд хэсгээр Орхон гол, төв хэсгээр Нилчингийн хөндий үргэлжлэх ба хөрсний хувьд нунтаг карбонатлаг ба карбонатгүй нимгэн хар хүрэн хөрс тархсан байна.

Бид дээрхи зураглалд илэрсэн элс бүхий талбайг шалгах зорилгоор хээрийн судалгаагаар координат авч хилийн тодорлыг давхцуулсан (2 дугаар зураг).



2 дугаар зураг. Хуст Өндөр уулын зүүн талын хөндийд байрлах бүрхэвч элс



2 дугаар зураг. 1984 оны Байрзүйн зурагт Шийрийн хөндийн элс дүрслэгдсэн байдал

Тус сумын элс нь ерөнхий хуримтлалын хэлбэрийн хувьд Бүрхэвч болон Довцог элс тархсан байна. Дээрх хэлбэрийн элсийг дэлгэрүүлбэл: Бүрхэвч элс их төлөв талархаг газар, долгиот тал, ухаа гүвээрхэг гадарга ба бэлийн хэвгий талыг харьцангуй тэгш үеэр хучиж тогтсон байдаг. Бүрхэвч элсний зузаан төдийлөн их биш, дунджаар 10-60см, хааяа 1м хүрэх ба ихэнхдээ өвслөг, сөөгөнцөр ургамлаар, зарим тохиолдолд

харгана, буйлс, заг зэрэг сөөглөг ургамлаар бэхлэгдсэн буюу тэдгээрт бэхжсэн байдаг. Тус элсний өөр нэг хэлбэр бол төгс ургамалжсан дарагдмал байдалтай бүрхэвч элс юм. Ийм төрлийн элстэй газрын ургамал бүрхэвчийг зүй бус хөндөх, бэлчээрт сэлгээгүй давтан давтан ажиглах, нүх шуудуу ухаж сэндийчих зэргээр өнгөн хөрсийг гэмтээхээс байнга сэргийлж аж ахуй, зам тээвэрт ашиглахдаа онцгой болгоомжтой, зөв харьцах, өөрөөр хэлбэл ашиглалт хамгаалалтыг зохистой хослох шаардлагатай. Эс тэгвэл элс нь сулран хийсч өргөн уудам нутаг бэлчээр элсжих цөлжих аюултай болно.

Дов, овоо хэлбэртэй, төдийлөн өндөр биш (1-4м), салхин талын болон салхины доод талын хажуу нь морфологийн ялгаваргүй, дугуй буюу бага зэрэг сунасан плантай элсэн хуримтлалын эерэг хэлбэрийг довцог элс гэнэ [2].

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. [1] – Монгол Улсын Үндэсний Атлас, 2006
2. [2] - Баасан , Т. (2003). Монгол орны элс. Улаанбаатар: Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх үйлдвэр.
3. Loadmap.net
4. Glovis.usgs.gov